



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025. 06. 27 № 26

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА Т.ЖАМБААЖАМЦ
ТАНАА

Г Санхүүгийн зохицуулах хороо
хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй
холбоотой асуудлаар

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу танай байгууллагын хяналт, зохицуулалтын чиг үүрэгт хамаарах зээлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгож буй зээлийн бодит өртгийн бүтэц, өртгийг хэрхэн, ямар аргачлал, журам, хууль тогтоомжийн дагуу тогтоож байгаа мэдээллийг зээлийн бүтээгдэхүүний төрөл тус бүрээр, түүнчлэн зээлийн хүүгээс бусад зээлийн өртөг болох шимтгэл, хураамжийг тогтоодог болон тогтоодоггүй зээлийн бүтээгдэхүүний талаарх мэдээлэл, шимтгэл, хураамжийг үндэслэлтэй тогтоодог эсэх, шимтгэл, хураамж холбоотой зээлдэгч, хэрэглэгчийн ирүүлдэг гомдолын агуулга, тоо /сүүлийн таван жилээр/, энэ чиглэлээр хэрэглэгчийг хамгаалах бодлогын талаарх мэдээллийг хуульд заасан хугацааны дотор бичгээр ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

П.САЙНЗОРИГ



2025000037